

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

1. Аудитын гэрчилгээ .....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	6
2.9. Зорилтот түвшин, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	7
Анхаарал татахуйц асуудал байхгүй байна. ....	7
2.12. Шилэн дансны мэдээлэл .....	7
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	7
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	7
3. Менежментийн захидал.....	8
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	10
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	10
4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан .....	11
4.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан .....	12
4.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	13
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	14

### Товчилсон үгийн жагсаалт

ҮАГ	Үндэсний аудитын газар
САГ	Санхүүгийн аудитын газар
СТОУС	Санхүүгийн тайлангийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

БАГАБАЯН ЭНХИЙН ТӨЛӨӨ  
ЦОГЦОЛБОР ТӨВ ТӨҮГ-ЫН  
ЗАХИРАЛ Д.БАТБААТАР ТАНАА

2020.03.13 № 06/781  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Багабаян энхийн төлөө цогцолбор төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Багабаян энхийн төлөө цогцолбор төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нятлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Багабаян энхийн төлөө цогцолбор төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Багабаян энхийн төлөө цогцолбор төв нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Санхүүгийн тайлагналын болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Багабаян энхийн төлөө цогцолбор төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус төвийн захирал Д.Батбаатар Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа Нягтлан бодох бүртгэлийн хуулийн заалтыг хэрэгжүүлэх, авлагын үлдэгдлийг тооцоо нийлж актаар баталгаажуулж байх, найдваргүй авлага үүсэхээс сэргийлж, авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулж ажиллах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Багабаян энхийн төлөө цогцолбор төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Багабаян энхийн төлөө цогцолбор төвийн 2019 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Багабаян энхийн төлөө цогцолбор төвийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 12 дугаар сарын 24-ний өдрөөс 2020 оны 3-р сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 3 дугаар сарын 13-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар Стандарт дүгнэлт аудит ХХК-ийн аудитор А.Цэрэнчимэд, аудиторовн туслах Б.Анармаа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Багабаян энхийн төлөө цогцолбор төв ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Стандарт дүгнэлт аудит ХХК-д 2020 оны 2 дүгээр сарын 10-ны өдрийн 49 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

## **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Багабаян энхийн төлөө цогцолбор төвийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь *"Батлан хамгаалах салбарын цэргийн албан хаагчид, өндөр настан, ахмад дайчид, Монгол улсын болон гадаадын энхийг сахиулагчид, цэргийн албан хаагчид, зочид, амрагчдад сэтгэл ханамжтай үйлчилгээ үзүүлэх, аялал жуулчлалыг хөгжүүлэх, батлан хамгаалах салбарын хөгжил дэвшилд хувь нэмэр оруулах, Монгол улсын болон олон улсын жишиг стандартад нийцсэн амралтын үйлчилгээг үзүүлэхэд"* -д оршино.

Багабаян энхийн төлөө цогцолбор төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний удирдлагаас дэвшүүлсэн зорилго, зорилтыг ханган биелүүлж, удирдлага, зохион байгуулалт, амралт үйлчилгээний зөв менежментийг хэрэгжүүлэх,
- Амрагчдын ая тухтай, үйлчилгээний соёлч, шуурхай байдал, амралтын орчны эрүүл ахуй, тохижилтыг Монгол Улсын болон олон улсын жишиг стандарт MNS4958:2000-д нийцүүлсэн өндөр түвшинд хүргэх,
- Ашиг, орлогоо нэмэгдүүлэх, үр ашиггүй зардлыг багасгах, санхүүгийн бүртгэл тооцоог сайжруулах, 2019 оны бараа материал хүнсний материал худалдан авах төлөвлөгөөг боловсруулж, "Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай" хуульд нийцүүлж, сонгон шалгаруулалт, тендерийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх,
- Ажилчин албан хаагчдын хөдөлмөрийн сахилга бат, ажлын хариуцлага, гүйцэтгэх чадвар, хууль эрх зүйн мэдлэг, харьцааны соёл, мэргэжлийн боловсролыг дээшлүүлэх,

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Багабаян энхийн төлөө цогцолбор төв нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд "Даймонд-5" программ хангамж ашигладаг байна.

Багабаян энхийн төлөө цогцолбор төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Багабаян энхийн төлөө цогцолбор төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитыг төлөвлөлтийн үе шатанд 36 асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг бага гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 4,049.2 сая төгрөгөөс тооцон 40.5 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 3,994.9 сая төгрөгөөс тооцон 39.9 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Багабаян энхийн төлөө цогцолбор төв ТӨҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 71.0 сая төгрөгөөр буюу 1.7 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, нийт өр төлбөр, эздийн өмчийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өөрчлөлт
			3=2-1
Б	1	2	
Мөнгөн хөрөнгө	62.0	23.9	(38.1)
Авлага	116.2	127.5	11.3
Урьдчилж гарсан зардал	1.4	00.0	(1.4)
Бараа материал	292.8	324.0	31.2
Бусад эргэлтийн хөрөнгө	22.5	22.3	(0.2)
Үндсэн хөрөнгө	3,611.6	3,537.8	(73.8)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>4,106.5</b>	<b>4,035.5</b>	<b>(71.0)</b>
Өр төлбөр	57.4	40.6	(16.8)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	4,049.1	3,994.9	(54.2)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>4,106.5</b>	<b>4,035.5</b>	<b>(71.0)</b>

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 38.1 сая төгрөгөөр буурсан нь өмнөх оны үлдэгдлээс үйл ажиллагаандаа зарцуулсантай холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл өссөн нь тайлант онд 11.3 сая төгрөгийн ажилчдаас болон байгууллагаас авах авлага нэмэгдсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 31.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд 1,025.2 сая төгрөгийн бараа материал худалдан авч, 994.1 сая төгрөгийн бараа материал зарцуулж, нүүрс, сэлбэг хэрэгслийн үлдэгдэл нэмэгдсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл буурсан нь батлагдсан төлөвлөгөөний дагуу Батлан хамгаалах яамны сайдын А/291, А/376 тоот тушаалаар 48.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан, Батлан хамгаалах яамны сайдын А/51 тоот тушаалаар 7.1 сая төгрөгийн хөрөнгө шилжүүлж авсан, Батлан хамгаалах яамны сайдын А/376 тоот тушаалаар 40.2 сая төгрөгийн тоног төхөөрөмж, программ хангамж, биет бус хөрөнгө акталж данснаас хасалт хийсэн, хуримтлагдсан элэгдэл 89.6 сая төгрөгөөр нэмэгдсэнээс тус тус шалтгаалжээ.

Богино болон урт хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 16.8 сая төгрөгөөр буурсан нь урд онд авсан халаалтын зардалд хэрэглэх нүүрсний төлбөрийг барагдуулсан нь нөлөөлжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,994.9 сая төгрөг болсон нь тайлант онд 54.3 сая төгрөгөөр алдагдалтай ажилласнаас шалтгаалжээ. 2017 оноос эхлэн энхийг сахиулагч САГ-2020/49/СТА-ТӨҮГ

цэргийн албан хаагчдын амрах нэг өдрийн зардлыг 57,000 төгрөгөөр тооцож байгаагаас энхийг дэмжих ажиллагаанаас 39.1 сая төгрөгийн алдагдал хүлээсэн байна. Энхийг дэмжих ажиллагааны алдагдал нь нийт алдагдлын 72.1 хувийг эзэлж байна. Тус төв нь энхийг сахиулагчдын нэг өдрийн зардлыг 81,000 төгрөгөөр тооцохоор тооцоо хийж, Батлан хамгаалах яаманд хандаад хүлээгдэж байна.

## **2.9. Зорилтот түвшин, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Батлан хамгаалах яамнаас Багабаян энхийн төлөө цогцолбор төвийн 2019 оны үйл ажиллагааны орлого, зардлыг батлахдаа 1,477.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, 1,428.3 сая төгрөгийн зарлага гаргаж, 48.7 сая төгрөгийн ашигтай ажиллахаар тооцож, баталсан байна.

Багабаян энхийн төлөө цогцолбор төв нь тайлант онд 1,587.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны зардалд 1,642.0 сая төгрөг зарцуулж, 54.2 сая төгрөгийн алдагдалтай ажиллажээ. Орлого нь өмнөх оныхоос 48.1 сая, зардал нь 62.6 сая төгрөгөөр тус тус буурсан байна.

Батлагдсан төсвийг гүйцэтгэлтэй харьцуулахад орлогыг 107.5 хувь буюу 110.8 сая төгрөгөөр илүү төвлөрүүлж, зардлыг 213.7 сая төгрөгөөр илүү зарцуулж 54.2 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

## **2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд 36 эрсдэл тодорхойлж нийт 36 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 8.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

## **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

## **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан тухайн жилийн батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэмнэлт, хэтрэлтийн шалтгаан, цалингаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мэдээллийг хугацаанд нь 38, хугацаа хоцроож байршуулсан 5 мэдээлэл байна.

## **2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 2 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

## **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Багабаян энхийн төлөө цогцолбор төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Багабаян энхийн төлөө цогцолбор төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, СТОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Залруулаагүй 8.8 сая төгрөгийн алдаа зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшингээс бага байгаа тул зөрчилгүй дүгнэлт өгч байна.



### 3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### 3.1 *Балансын данстай холбоотой асуудал*

3.1.1 *Илрүүлэлт:* Нийт дөрвөн байгууллагаас авах 4.8 сая төгрөгийн авлагыг жилийн эцсээр тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-т *"Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах"* 20.2.6-д *"Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах"* гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн *"Эрх ба үүрэг"* батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.1.2 *Эрсдэл:* Санхүүгийн тайлан, тодруулга буруу илэрхийлэгдэх, холбогдох стандарт, хууль, тогтоомж зөрчигдөх эрсдэлтэй.

3.1.3 *Өгсөн зөвлөмж:* Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д заасан заалтыг хэрэгжүүлж авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулж байх, авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч цаашид зөрчлийг давтан гаргахгүй ажиллах.

3.1.4 *Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* Асуудлыг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэхээр болсон.

#### 3.2 *Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой асуудал*

3.2.1 *Илрүүлэлт:* 2017 онд үүссэн Монголын боксын холбооноос авах 4.0 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д *"Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах"* гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн *"Эрх ба үүрэг"* батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2.2 *Эрсдэл:* Найдваргүй авлага үүсэх эрсдэлтэй.

3.2.3 *Өгсөн зөвлөмж:* Авлагыг барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авч, цаашид зөрчлийг давтан гаргахгүй ажиллах.

3.2.4 *Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* Асуудлыг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэхээр болсон.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31 /төгрөг/
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	62,065,974.80	23,904,321.13
1.1.2	Дансны авлага	115,690,553.73	126,448,413.11
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	556,374.12	1,102,823.44
1.1.4	Бусад авлага		
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	292,865,448.47	323,971,289.09
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	1,301,381.48	0.00
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	22,380,465.66	22,259,622.81
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>494,860,198.26</b>	<b>497,686,469.58</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	3,607,088,961.17	3,530,884,960.04
1.2.2	Биет бус хөрөнгө	4,551,303.30	6,915,089.38
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>3,611,640,264.47</b>	<b>3,537,800,049.42</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>4,106,500,462.73</b>	<b>4,035,486,519.00</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	34,406,120.55	6,237,470.55
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр	14,633,442.96	30,643,854.71
2.1.1.10	Бусад өглөг	4,776,556.00	
2.1.1.12	Хойшлогдсон татварын өр	3,493,851.65	3,657,016.91
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>57,309,971.16</b>	<b>40,538,342.17</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>	-	-
<b>2.1.2.6</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	-	-
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>57,309,971.16</b>	<b>40,538,342.17</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч: - төрийн	943,008,420.00	943,008,420.00
2.3.2	- хувийн		
2.3.3	- хувьцаат		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	2,095,895,116.30	2,095,895,116.30
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	580,892,169.99	580,892,169.99
2.3.9	Хуримтлагдсан ашиг	429,394,785.28	375,152,470.54
2.3.10	Тайлант үеийн ашиг/алдагдал		
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>4,049,190,491.57</b>	<b>3,994,948,176.83</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>4,106,500,462.73</b>	<b>4,035,486,519.00</b>

## 4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	/төгрөг/	
		2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	<b>1,486,144,102.61</b>	<b>1,501,388,846.98</b>
2	Борлуулалтын өртөг	1,155,275,043.25	650,643,855.30
3	<b>Нийт ашиг ( алдагдал)</b>	<b>330,869,059.36</b>	<b>850,744,991.68</b>
4	Түрээсийн орлого	272,727.27	-
5	Хүүний орлого	646,474.32	500,351.05
7	Эрхийн шимтгэлийн орлого	49,551,197.64	9,353,941.80
8	Бусад орлого	99,252,534.59	76,498,911.76
9	Борлуулалт, маркетингийн зардал	10,748,827.81	386,086,815.98
10	Ерөнхий ба удирдлагын зардал	308,161,487.37	540,529,221.04
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	93,992,467.04	53,619,207.28
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(4,873,049.48)	(10,976,910.53)
17	Бусад алдагдал		
18	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг ( алдагдал)</b>	<b>62,816,161.48</b>	<b>(54,113,958.54)</b>
19	Орлогын татварын зардал	6,281,616.14	128,356.20
20	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>56,534,545.34</b>	<b>(54,242,314.74)</b>
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)	56,534,545.34	(54,242,314.74)
24	<b>Орлогын нийт дүн</b>	<b>56,534,545.34</b>	<b>(54,242,314.74)</b>
25	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>		

### 4.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2017-12-31-ний үлдэгдэл	943,008,420.00	12,558,676.16	580,892,169.99	372,857,600.20	1,909,316,866.35
3	Залруулсан үлдэгдэл	943,008,420.00	12,558,676.16	580,892,169.99	372,860,239.94	1,909,316,866.35
	НББ-ийн өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	2,639.74	2,639.74
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	56,534,545.34	56,534,545.34
5	Өмчид гарсан өөрчлөлт	-	2,083,336,440.10	-	-	2,083,336,440.10
7	2018-12-31-ний үлдэгдэл	943,008,420.00	2,095,895,116.26	580,892,169.99	429,394,785.32	4,049,190,491.57
8	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(54,242,314.74)	(54,242,314.74)
9	2019-12-31-ний үлдэгдэл	943,008,420.00	2,095,895,116.26	580,892,169.99	375,152,470.58	3,994,948,176.83

#### 4.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31 /төгрөг/
1	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	<b>1,705,285,106.48</b>	<b>1,708,399,188.73</b>
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,613,693,637.85	1,604,008,172.01
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-
	Буцаан авсан албан татвар	84,199,123.18	93,669,850.82
	Бусад мөнгөн орлого	7,392,345.45	10,721,165.90
1.2	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>1,689,137,650.38</b>	<b>1,698,154,814.78</b>
	Ажиллагчдад төлсөн	240,884,822.00	322,758,701.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	107,701,877.47	140,743,783.96
	Бараа материал худалдан авахад төлсөн	936,325,682.06	1,037,951,570.80
	Ашиглалтын зардалд төлсөн	37,367,194.54	2,179,000.00
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	6,680,519.09	923,000.00
	Хүүний төлбөрт төлсөн	-	-
	Татварын байгууллагад төлсөн	188,363,306.00	111,773,243.27
	Даатгалын төлбөрт төлсөн	666,090.00	273,000.00
	Бусад мөнгөн зарлага	171,148,159.22	81,552,515.75
1.3	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>16,147,456.10</b>	<b>10,244,373.95</b>
2	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	<b>646,473.72</b>	<b>500,351.05</b>
	Хүлээн авсан хүүгийн орлого	646,473.72	500,351.05
	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	48,906,378.67
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	48,906,378.67
2.3	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>646,473.72</b>	<b>(48,406,027.62)</b>
3	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	-
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
	Төлсөн ногдол ашиг	-	-
3.3	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	-	-
	<b>Валютын ханшийн зөрүү</b>	-	-
4	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>16,793,929.82</b>	<b>(38,161,653.67)</b>
5	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>45,272,044.98</b>	<b>62,065,974.80</b>
6	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>62,065,974.80</b>	<b>23,904,321.13</b>

**5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

Огноо:	Аудитын нэр:	<b>Багабаян энхийн төлөө цогцолбор төвийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит</b>	Аудитын код:
2020-03-06			<b>САГ-2020/49/СТА-ТӨААТҮГ</b>
Шалгагдсан байгууллагын нэр:		<b>Багабаян энхийн төлөө цогцолобор төв ТӨААТҮГ</b>	Сая төгрөгөөр

	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаа с гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны нэр	
				4	5
	1	2	3	4	5
1	Нийт дөрвөн байгууллагаас авах авлагыг жилийн эцсээр тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна	4.8	Зөвлөмж өгөх	Багабаян энхийн төлөө цогцолбор төв ТӨААТҮГ-ын захирал, нягтлан бодогч	Д.Батбаатар Д.Дэлгэрмаа
2	2017 онд үүссэн Монголын боксын холбооноос авах авлагыг барагдуулаагүй байна.	4.0	Зөвлөмж өгөх	Багабаян энхийн төлөө цогцолбор төв ТӨААТҮГ-ын захирал, нягтлан бодогч	Д.Батбаатар Д.Дэлгэрмаа
	<b>Дүн</b>	<b>8.8</b>			

